



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГУУДТАЙ НИЙЦСЭН БОНДЫН ҮР НӨЛӨӨГ ХЭМЖИХ, ТАЙЛАГНАХ

ГАРЫН АВЛАГА

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
ЗОРИЛГУУДАЙ НИЙЦСЭН БОНДЫН
ҮР НӨЛӨӨГ ХЭМЖИХ, ТАЙЛАГНАХ

ГАРЫН АВЛАГА

Энэхүү гарын авлагыг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг дэмжих" техникийн туслалцааны төслийн "Тогтвортой Хөгжлийн Зорилгын үр нөлөөний хэмжилт, тайлагнал" дэд төслийн хүрээнд Сангийн яам, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөртэй хамтран боловсруулав.

Энэхүү зөвлөхийн тайлан нь АХБ эсвэл холбогдох Засгийн газрын байр суурийг илэрхийлэхгүй бөгөөд АХБ болон Засгийн газар түүний агуулгын төлөө хариуцлага хүлээхгүй.

@ 2024

Гарын авлагыг боловсруулсан:

"Хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг дэмжих"- "Тогтвортой Хөгжлийн Зорилгын үр нөлөөний хэмжилт, тайлагнал" техникийн туслалцааны төслийн зөвлөх баг:

Зөвлөх: Г. Цэвээндорж
М. Тулга
С. Золжаргал

Гарын авлагыг хянан тохиолдуулсан:

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр:

Хөтөлбөрийн шинжээч: Т. Дэлгэрнаран

Тогтвортой санхүүжилт
хариуцсан мэргэжилтэн: Д. Цолмон

АГУУЛГА

ЗУРГИЙН ЖАГСААЛТ	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	4
Танилцуулга	5
Ерөнхий зүйл	6
1. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлага, хуваарилалт	9
2. Зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг тодорхойлох, шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшнийг тогтоох	11
2.1 Зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг тодорхойлох	12
2.2 Шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшнийг тогтоох	18
2.3 Сөрөг үр нөлөө	19
3. Тайлагнал (Хуваарилалтын тайлан, Үр нөлөөний тайлан)	20
3.1 Хуваарилалтын тайлан	20
3.2 Үр нөлөөний тайлан	21
3.3 Үр нөлөөний тайлагналын зарчим, арга зүй	24
4. Өгөгдөл, мэдээллийн удирдлага	26
Дүгнэлт	29

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. ТХЗНБ-ын баримт бичигт туссан зардал, төсөл, арга хэмжээг тодорхойлох, үнэлэх, сонгох, хуваарилах, тайлагнах үе шат	8
Зураг 2. Зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг тодорхойлох, хэмжих, тайлагнах үйл явц	12
Зураг 3. Логик шинжилгээний загвар	13
Зураг 4. Сэргээгдэх эрчим хүчний үр нөлөөний логик шинжилгээний жишээ	14
Зураг 5. Ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн талбайг нэмэгдүүлэх төслийн үр нөлөөний логик шинжилгээний жишээ	15
Зураг 6. Эрүүл мэндийн хүртээмжийг сайжруулах үр нөлөөний логик шинжилгээний жишээ	15
Зураг 7. Ногоон цэцэрлэгийн барилгын үр нөлөөний логик шинжилгээний жишээ	16
Зураг 8. Зардал, төсөл арга хэмжээний өгөгдөл мэдээлийг бэлтгэх, сонгох, хянах, баталгаажуулах үйл явцыг хураангуй	27

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргах бүтэц, агуулга	22
--	----

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Зардал, төсөл, арга хэмжээний мэдээлэл цуглуулах хүснэгт	30
Хавсралт 2. Үр нөлөө болон хуваарилалтын тайлагналын хүснэгт	31
Хавсралт 3. Үр нөлөөний тайлан гаргахад анхаарах асуудлууд	32

ТАНИЛЦУУЛГА

Тогтвортой Хөгжлийн Зорилготой Нийцсэн Бонд (цаашид ТХЗНБ гэх)-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжихээр батлагдсан зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг хэрхэн тодорхойлох, хэмжих, мөн тухайн зардал, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, түүний үр дүн, үр нөлөөг хэрхэн тайлагнах талаар шаардлагатай мэдээллээр хангах нь энэхүү гарын авлагын үндсэн зорилго юм. Тус гарын авлага нь дөрвөн хэсгээс бүрдэнэ.

Гарын авлагын эхний хэсэгт ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлага, түүний хуваарилалтыг хэрхэн хийх талаар ерөнхий мэдээлэл, шаардлагыг тусгасан. Тус шаардлага нь ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгийг Засгийн газраар баталгаажсан зардал, төсөл, арга хэмжээнд хуваарилах үйл ажиллагаанд оролцогч талууд, тэдгээрийн эрх, үүргийг болон хуваарилалт хийх зарчим, шаардлага, нөхцөлийг тусгасан.

Хоёр дахь хэсэгт ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжихээр батлагдсан зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг логик шинжилгээ болон өөрчлөлтийн онолуудыг ашиглан тодорхойлох, хэмжих, үр нөлөөний шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшин (ex-ante expected impact)-г хэрхэн тооцох талаар аргыг дэлгэрэнгүй тайлбарласан.

ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжихээр батлагдсан зардал, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, түүний үр дүн, үр нөлөөг Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо (ICMA)-ноос гаргасан зарчмуудын дагуу хэрхэн тайлагнах талаар тус гарын авлагын гурав дахь хэсэгт орууллаа.

Дөрөв дэх хэсэгт өгөгдөл, мэдээллийн удирдлагын талаар буюу өгөгдөл, мэдээллийг цуглуулах, боловсруулах, бүртгэх, баталгаажуулах, тайлагнах үе шат бүрийн тодорхой дарааллыг холбогдох тайлбарын хамт тус гарын авлагад тусгалаа.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ _____...

Сангийн яамнаас "Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Зорилгуудтай Нийцсэн Бондын Баримт Бичиг" (цаашид ТХЗНБ-ын баримт бичиг)-ийг 2023 онд гаргасан. Энэхүү ТХЗНБ-ын бондын баримт бичгийн зорилго нь Монгол Улс ТХЗ-той нийцсэн байгаль орчин, нийгмийн үр өгөөжийг бий болгох шаардлагыг хангасан зардал, төсөл, арга хэмжээ (зардлын зориулалт гэж ойлгоно)-г сонгож, тухайн бондын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр шинээр эсвэл дахин санхүүжүүлэх, бондын зарцуулалт болон байгаль орчин, нийгэмд үзүүлж буй үр нөлөөг тайлагнах зэрэг үйл ажиллагаатай холбоотой нөхцөл, үйл явцыг тодорхойлох юм (ТХЗНБ-ын баримт бичиг, 2023).

Уг ТХЗНБ-ын баримт бичгийг боловсруулахдаа Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо (цаашид ОУХЗЗХ гэх)-ноос нийтэлсэн «Ногоон бондын зарчмууд», «Нийгмийн бондын зарчмууд» болон «Тогтвортой хөгжлийн бондын удирдамж» зэрэг олон улсын бондын стандартуудтай нийцүүлсэн (ТХЗНБ-ын баримт бичиг, 2023).

ТХЗНБ-ын баримт бичиг нь ОУХЗЗХ-ны бондын зарчмуудын дагуу доорх дөрвөн үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг. Үүнд:

1. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт
2. Зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох
3. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлага
4. Тайлагнал

Энэхүү гарын авлагад татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлага, тайлагналын үйл явцыг дэлгэрэнгүй байдлаар авч үзнэ. Өөрөөр хэлбэл, "3. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлага", "4. Тайлагнал" -тай холбоотой үйл ажиллагаа, арга хэмжээг тус гарын авлагад тайлбарлана.

ТХЗНБ гаргах, татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлтэй холбоотой аливаа үйл ажиллагааг тус гарын авлагад авч үзээгүй болно. Харин ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж эхэлснээс хойш жил бүр хэрхэн тайлан гаргах, үр нөлөөг хэмжих талаар аргачлалыг энэ гарын авлагад тусгасан. Тайлан гаргах, үр нөлөөг хэмжихтэй холбоотой өгөгдөл, мэдээллийг цуглуулах, боловсруулах, харьцуулах талаар үйл явцыг мөн уг гарын авлагад тайлбарласан.

ТХЗНБ-ын баримт бичгийн хүрээнд бонд гаргаж, бондын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр ТХЗ, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр, Үндэсний дасан зохицох төлөвлөгөө зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн зардал, төсөл, арга хэмжээнүүдийг санхүүжүүлнэ. Тус зардал, төсөл, арга хэмжээ нь ТХЗНБ-ын баримт бичигт туссан зарчим, шалгуур үзүүлэлтийг хангасан байх шаардлагатай юм. Зардал, төсөл, арга хэмжээ нь хөрөнгө оруулалтын зардал, татаас, зээл, тусламж, татварын зардал (татварын хөнгөлөлт, чөлөөлөлт), үйл ажиллагааны зардлууд, интервенцийн зардлууд (ТӨҮҮГ олгох шилжүүлэг, татаас) гэсэн 5 төрлийн зардлаас бүрдэнэ.

ТХЗ-той нийцсэн байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг бий болгох шаардлагыг хангасан 10 салбар, уг салбаруудын бодлого, үйл ажиллагааг шууд хариуцах 9 яаманд хэрэгжих зардал, төсөл, арга хэмжээнүүд нь уг ТХЗНБ-ын баримт бичигт хамаарч байна.

Энэ гарын авлагад ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгийг хэрхэн удирдах, зардал, төсөл, арга хэмжээнд хэрхэн хуваарилах, тэдгээрийн үр нөлөөг хэрхэн хэмжих, зардал, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, зарцуулалтыг жил бүр хэрхэн тайлагнах аргачлалыг үе шат бүрээр тайлбарлах болно.

Бондын татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлага, хуваарилалт, зарцуулалтыг тайлагнахын өмнө ТХЗ-той нийцсэн байгаль орчин, нийгмийн үр өгөөжийг бий болгох зардал, төсөл, арга хэмжээг сонгож, баталгаажуулсан байх шаардлагатай байдаг. "ТХЗ-ыг төсвийн зарлагатай холбох аргачлал, олон улсын туршлага", "ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлтийг хангасан зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох" гэсэн 2 тусдаа гарын авлагад тусгасны дагуу ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээг үнэлж, сонгоно. Зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох үйл ажиллагааг ТХЗНБ гаргахаас өмнө хийж гүйцэтгэнэ. Дээр дурдсан 2 гарын авлагаас зардал, төсөл, арга хэмжээг хэрхэн сонгох талаар дэлгэрэнгүй мэдээллийг бүрэн авах боломжтой бөгөөд энэхүү гарын авлагад энэ талаар тусгайлан авч үзээгүй.

ТХЗНБ-ын баримт бичигт туссан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох ажлыг дараах 6 үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ.

1. ТХЗ-той төсвийн зарлагыг холбох (SDG Budget Tagging)
2. ТХЗ-той холбогдсон зарлагыг Бондын шалгуур үзүүлэлттэй уялдуулах
3. Хориглох үйл ажиллагааны жагсаалттай тулгах
4. Зардал, төсөл, арга хэмжээний санал хүргүүлэх (дэлгэрэнгүй жагсаалт)
5. Зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох (хураангуй жагсаалт)
6. Зардал, төсөл, арга хэмжээг баталгаажуулах

Зураг 1-т үзүүлснээр эхний шатанд салбарын яам нь ТХЗНБ-оор санхүүжих зардал, төсөл, арга хэмжээг тодорхойлохдоо ТХЗ-той төсвийн зарлагыг холбосон байх шаардлагатай юм.

Дараагийн шатанд салбарын яам нь ТХЗ-той холбогдсон зарлагыг бондын шалгуур үзүүлэлттэй уялдуулах, хориглох үйл ажиллагааны жагсаалттай тулгах замаар шаардлага хангасан зардал, төсөл, арга хэмжээний жагсаалтыг гаргана. ТХЗНБ-ын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтийг хангасан зардал, төсөл, арга хэмжээг тухайн салбарын яам нь Монгол Улсын хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэл, ач холбогдлоор нь эрэмбэлсэн дэлгэрэнгүй жагсаалтыг гаргаж Сангийн яаманд хүргүүлнэ.

Сангийн яам нь "Монгол Улсын ТХЗНБ-ын баримт бичиг", "ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлтийг хангасан зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох" гарын авлагын дагуу зардал, төсөл, арга хэмжээний хураангуй жагсаалтыг гаргана.

Засгийн газар нь сонгогдсон зардал, төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталгаажуулах бөгөөд ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр цаашид эдгээр зардал, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх юм.

Зураг 1. ТХЗНБ-ын баримт бичигт туссан зардал, төсөл, арга хэмжээг тодорхойлох, үнэлэх, сонгох, хуваарилах, тайлагнах үе шат



Эх сурвалж: Монгол Улсын ТХЗНБ-ын баримт бичиг, Төслийн зөвлөхүүд

ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгийг хэрхэн удирдах, зардал, төсөл, арга хэмжээнд хэрхэн хуваарилах, зардал, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, зарцуулалтыг жил бүр тайлагнах ажлыг дараах 3 үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлага, хуваарилалт
2. Зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг тодорхойлох, шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшнийг тогтоох
3. Тайлагнах

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА, ХУВААРИЛАЛТ

Зардал, төсөл, арга хэмжээг үнэлж, сонгож, баталгаажуулсны дараа ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгийг зөвшөөрөгдөх зардлуудад хуваарилна. 2023 онд батлагдсан ТХЗНБ-ын баримт бичигт тусгагдсаны дагуу ТХЗНБ-ыг гаргасан өдрөөс хойш 24 сард багтаан бүрэн зарцуулсан байна.

Сангийн яам ТХЗНБ-ыг гаргах ажлыг хариуцах ба ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгийг зөвшөөрөгдсөн зардлуудад хуваарилах, ашиглах үйл ажиллагаанд хяналт тавина. Бондын татан төвлөрүүлсэн хөрөнгийг Төрийн санд байршуулж, хуваарилна.

Монгол Улс ТХЗНБ нэг бүрийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн хуваарилалтыг зохицуулах, татан төвлөрүүлсэн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж буйд хяналт тавихын тулд ТХЗНБ-ын бүртгэл хөтөлнө. ТХЗНБ-ын бүртгэлийг Сангийн яам жил бүр хянан шалгана. Бондын бүртгэл нь дараах мэдээллийг агуулна. Үүнд:

- Зардлын тухай товч мэдээлэл;
- Зөвшөөрөгдсөн зардал тус бүрд хуваарилсан хөрөнгийн хэмжээ;
- Зөвшөөрөгдсөн зардлын байгаль орчин, нийгмийн хүлээгдэж буй үр нөлөө (Байгаль орчин, нийгэм/Байгаль орчин нийгэм засаглалын магадлан баталгаажуулалт);
- ТХЗНБ-ын зөвшөөрөгдөх зардалд хуваарилсан хөрөнгийн нийлбэр дүн;
- Татан төвлөрүүлсэн хөрөнгийн хуваарилагдаагүй үлдэгдэл;
- Хуваарилагдсан хөрөнгийн нийлбэрийг цаг тухай бүр бүртгэхэд шаардлагатай бусад мэдээлэл.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг захиран зарцуулж буй салбарын яамд нь ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх багцад байгаа зөвшөөрөгдсөн зардлын байгаль орчин, нийгмийн үр нөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, Сангийн яаманд жил бүр тайлагнах шаардлагатай. Зардал, төсөл, арга хэмжээний талаар өгөгдөл, мэдээллийг цуглуулах хүснэгтийг Хавсралт 1-т тусгасан.

Зардлыг санхүүжилтээс хасах эсвэл төслийн хэрэгжилтийг зогсоосон тохиолдолд өөр бусад зөвшөөрөгдсөн зардлыг шинээр эсвэл дахин санхүүжүүлэхэд зарцуулагдах хүртэл Сангийн яам тухайн татан төвлөрүүлсэн хөрөнгийг "хуваарилагдаагүй" гэж тэмдэглэнэ.

Монгол Улс ТХЗНБ-ын хуваарилагдаагүй хөрөнгөтэй тэнцүү хэмжээний хөрөнгийг, зөвшөөрөгдсөн зардлуудад хуваарилагдах хүртэл түр хугацаагаар Төрийн санд хадгална.

Хуваарилалт

ТХЗНБ-ыг олон улсын зах зээлд гаргасны дараа Засгийн газраар баталгаажуулсан зардал, төсөл, арга хэмжээний жагсаалд үндэслэн татан төвлөрүүлсэн хөрөнгийг холбогдох эрх бүхий байгууллага хуваарилна. ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр зардал, төсөл, арга хэмжээг хэсэгчлэн буюу бүхэлд нь, мөн шинээр болон дахин санхүүжүүлж болно.

Хуваарилалт хийх ажил дууссаны дараа ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тодорхойлогдсон зардал, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явцыг энэ гарын авлагад тусгаагүй. Өөрөөр хэлбэл, зардал, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтийг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсөв, санхүүгийн болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд салбарын яамд болон Сангийн яам хариуцна.

ТХЗНБ гаргахаас 3-аас илүүгүй жилийн өмнө байгаль орчин, нийгмийн чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын шаардлага хангасан зардлыг хэрэгжүүлэхэд зориулж зарцуулсан зарим зардлыг татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлж болно. Тусгай зориулалттай эх үүсвэрээр өмнө нь санхүүжүүлсэн зардлыг давхардуулан санхүүжүүлэхээс зайлсхийхийн тулд тухайн зардлыг зөвшөөрөгдөх зардалд оруулахгүй.

II. ЗАРДАЛ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР НӨЛӨӨГ ТОДОРХОЙЛОХ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШНИЙГ ТОГТООХ

Үр нөлөөний талаар нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, зарчим, тодорхойлолт дутмаг бөгөөд, үр нөлөөг хэмжихэд хүндрэлтэй байдаг. Өөрөөр хэлбэл, салбар болон зардал, төсөл, арга хэмжээ тус бүр өөрийн гэсэн онцлогтой байдаг тул үр нөлөө харилцан адилгүй байна. Зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг хэмжих, тайлагнах нь ил тод байдал, хариуцлагатай байдлыг хангахад чухал ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээ нь байгаль орчин, нийгэмд хэрхэн үр ашигтай, үр дүнтэй, үр нөлөөтэй зарцуулагдаж буйг хөрөнгө оруулагчдад нотолгоонд суурилсан байдлаар тайлагнах зорилготой юм. Иймд зардал, төсөл, арга хэмжээний үр дүн, үр нөлөөг тодорхойлох, хэмжих зайлшгүй шаардлага үүсэж байна.

Олон улсын санхүүгийн зах зээлийн холбоо (ОУХЗЗХ) -ноос «Үр нөлөө нь зардал, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр бий болох өргөн цар хүрээтэй, урт хугацааны үр дүн юм» гэж тодорхойлсон байна. Үр нөлөө нь зардал, төсөл, арга хэмжээний үйл ажиллагаа дууссанаас тодорхой хугацааны дараа (1 болон түүнээс дээш жил) гардаг. Зарим тохиолдолд бондын хугацаа дууссаны дараа үр нөлөө, өөрчлөлтийг хэмжих боломжтой болдог¹.

“Үр дүнд суурилсан төсөвлөлт” гарын авлагад “Үр нөлөө гэдэг нь тодорхой үр дүнд хүрснээр урт хугацаанд бий болох, улс оронд эсхүл нийгмийн, эдийн засгийн тодорхой салбар, хүрээнд ашиг тусаа өгөх өргөн цар хүрээтэй өөрчлөлтийг хэлнэ” гэж тодорхойлсон байна².

Төслийн хэрэгжилтийн хугацаанд тухайн зардал, төсөл, арга хэмжээний үйл ажиллагааг үр дүн, үр нөлөө рүү чиглүүлэх шаардлагатай. Үр нөлөө нь эерэг болон сөрөг, шууд болон шууд бус, хүлээгдэж буй болон санамсаргүй, тодорхой болон тодорхой бус зэрэг олон төрөл байдаг.

“ТХЗ-ын үр нөлөөний стандарт”-д эерэг үр нөлөө үзүүлэх зардал, төсөл, арга хэмжээнд нөөцийг хуваарилж, сөрөг үр нөлөөг үзүүлэх үйл ажиллагааг бууруулах, багасгахад анхаарах шаардлагатай гэж тусгасан байна³.

Үр нөлөө (impact) нь үр нөлөөний удирдлага (impact management), үр нөлөөний хэмжилт (impact measurement) гэсэн 2 бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг. Энэхүү гарын авлагад үр нөлөөний хэмжилтийн талаар авч үзнэ. **Үр нөлөөний хэмжилт** нь үр нөлөөний зорилгыг тодорхойлох, үр нөлөөний гүйцэтгэлийг хянах, үр нөлөөг үнэлэх үйл явцыг хэлдэг⁴.

Зарлагын үр ашиг, үр дүнтэй холбоотой чанарын үзүүлэлтүүдийг мөн харгалзан үзэх шаардлагатай бөгөөд энэхүү үр нөлөөг хэмжих, тайлагнахад үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт чухал үүрэг гүйцэтгэнэ.

1 ICMA. (2023). Harmonised Framework for Impact Reporting for Social Bonds

2 НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр. (2023). Үр дүнд суурилсан төсөвлөлт: гарын авлага.

3 UNDP. (2021). About the SDG Impact Standard

4 Boiardi, P. (2020). “Managing and measuring the impact of sustainable investments: A two-axes mapping”, OECD Development Co-operation Working Papers, No. 74, OECD Publishing, Paris,

ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр 10 салбар, 9 ТЕЗ-ын шаардлага хангасан зардал, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх бөгөөд шаардлага хангасан зардал, төсөл, арга хэмжээг хэрхэн үнэлэх, сонгох үйл ажиллагааг «Тогтвортой хөгжлийн зорилгуудтай нийцсэн бондын шалгуур үзүүлэлтийг хангасан зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох» гарын авлагад дэлгэрэнгүй дурдсан.

Зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг тодорхойлох, хэмжих, өгөгдөл, мэдээллийг цуглуулах үйл явцыг дараах үе шатуудаар хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг тодорхойлох түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийг сонгох
2. Шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшнийг тогтоох

Зураг 2. Зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг тодорхойлох, хэмжих, тайлагнах үйл явц



Эх сурвалж: Төслийн зөвлөхүүд

2.1 ЗАРДАЛ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР НӨЛӨӨГ ТОДОРХОЙЛОХ

Зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг урьдчилан тодорхойлох шаардлагатай бөгөөд ихэвчлэн логик шинжилгээ (Logic model) болон өөрчлөлтийн онол (Theory of change) гэсэн хоёр загварыг ашигладаг. Загвар бүр нь зардал, төсөл, арга хэмжээний үйл ажиллагаанууд бие биетэйгээ хэрхэн холбогдож, үр нөлөөнд хүрч байгааг тодорхойлж харуулдаг шугаман загвар юм⁵. Энэхүү 2 загваруудыг Засгийн газраар баталгаажсан зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг тодорхойлоход ашиглана.


Логик шинжилгээ (Logic Model)

Логик шинжилгээ нь үр нөлөөг тодорхойлоход ашиглагдах таван үе шат бүхий хэрэгжилт, өөрчлөлтийн үе шатуудаас бүрдэх шугаман загвар юм. Таван үе шат бүр өөр өөрийн гэсэн хэмжих шалгуур үзүүлэлтүүд, нэгжтэй байдаг. Логик шинжилгээ нь хэрэгжүүлэлтийн үе шатууд болох орц, үйл явц, гарц, өөрчлөлтийн үе шатууд болох үр дагавар, үр нөлөөнөөс бүрддэг.

5 Alex, N. (2021). Impact Measurement and Management in Sustainable Finance. ADB

Логик шинжилгээний дагуу үр нөлөө гэдэг нь өөрчлөлтийн нотолгоо бөгөөд орц, үйл явц, гарцын хэрэгжилтийг зөвхөн загварын төгсгөл дэх үр дагавар болон үр нөлөөгөөр хэмжинэ. Үр нөлөөг хэмжих нь нарийн төвөгтэй, цаг хугацаа их шаарддаг бөгөөд логик шинжилгээнд ашиглагдсан шалгуур үзүүлэлтүүдээр хэмжигдэнэ⁶.

Зураг 3. Логик шинжилгээний загвар



Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банк

- Орц (Input) нь тухайн зорилтот үр дүнг бий болгох гарц, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан зарцуулж буй санхүүгийн, хөрөнгийн, хүний нөөцийн, технологийн болон мэдээллийн нөөц юм.
- Үйл явц (Activities) нь хүлээгдэж буй үр нөлөөнд хүрэхийн тулд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа юм.
- Гарц (Output) нь орцыг ашиглаж бий болгосон хэмжиж болохуйц эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээ буюу шууд утгаараа хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн юм.
- Үр дагавар (Outcome) гэдэг нь гарцаар дамжуулан богино болон дунд хугацаанд хүрэхээр төлөвлөсөн олон нийт, иргэд, эсхүл нийгмийн тодорхой зорилтот бүлгийн хүртэх үр шим, ашиг тус юм. Өөрөөр хэлбэл гарцын нөлөөгөөр бий болж буй өөрчлөлт юм⁷.

Өөрчлөлтийн онол (Theory of change)

Өөрчлөлтийн онол нь логик шинжилгээтэй ижил шугаман загвар боловч тодорхой үйл ажиллагаа (эсвэл багц арга хэмжээ) нь богино, дунд, урт хугацаанд хэрхэн нөлөөлөх талаарх урьдчилан таамаглаж, үр нөлөөг тодорхойлдог илүү төвөгтэй загвар юм. Тодорхой цаг хугацаанд тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлснээр хүлээгдэж буй үр нөлөөнд хэрхэн хүрэх талаар ойлгох боломжийг өгдөг. Өөрчлөлтийн онолыг ашигласнаар үр нөлөөг тодорхойлох, хэмжих, удирдахад чухал ач холбогдолтой бөгөөд ямар өгөгдөл, мэдээллийг ямар цаг хугацаанд, ямар эх сурвалжаас цуглуулах шаардлагатай талаар ойлгоход тусалж, үр нөлөөг үнэлэхэд илүү анхаарах боломжийг олгодог.

Өөрчлөлтийн онол нь логик шинжилгээний адил орц, үйл ажиллагаанаас үр нөлөөнд хүрэх шугаман загвар боловч илүү олон хувьсагчтай, үр нөлөөнд хүрэх олон арга зам, урьдчилсан таамаглал, үр нөлөөний талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан стратеги, удирдлагын загвар юм.

Засгийн газраар баталгаажсан зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг дээрх 2 загварыг ашиглан холбогдох шалгуур үзүүлэлттэй уялдуулан, хэмжих нэгжийг тодорхойлох боломжтой юм.

⁶ Alex, N. (2021). Impact Measurement and Management in Sustainable Finance. ADB


⁷ НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр. (2023). Үр дүнд суурилсан төсөвлөлт: гарын авлага.

Логик шинжилгээний загварыг ашиглан үр нөлөөг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг дараах жишээнүүдээр үзүүлэв.

Зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг олон шалгуур үзүүлэлтүүд ашигласнаар бүрэн илэрхийлэх боломжтой. ТХЗНБ-оор санхүүжих зардал, төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг ТХЗНБ-ын баримт бичигт тусгагдсан "Боломжит шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалт" -нд багтсан 91 шалгуур үзүүлэлтээс сонгох бөгөөд тухайн зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг хамгийн сайн илэрхийлэх нэг ба түүнээс дээш шалгуур үзүүлэлтийг сонгож, хэмжинэ. Өөрөөр хэлбэл, "ТХЗ-ыг төсвийн зарлагатай холбох", "ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлтийг хангасан зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох" гарын авлагын дагуу сонгон шалгаруулсан зардал, төсөл, арга хэмжээг "Боломжит шалгуур үзүүлэлтийн жагсаалт" -нд тусгагдсан үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүдтэй холбоно.

Зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг тодорхойлох, хэмжих шалгуур үзүүлэлтийг холбох үйл ажиллагааг жишээгээр үзүүлэв. "Эрдэнэбүрэнгийн 90МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барих" төслийн үр нөлөөний шалгуур үзүүлэлтийг ТХЗНБ-ын баримт бичигт тусгагдсан "Боломжит шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалт" -ын холбогдох ангилал болох "Сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашиг буюу хэмнэлт" хэсгийн шалгуур үзүүлэлтээс логик шинжилгээ ашиглан сонгож, уялдуулсныг доор жишээгээр Зураг 4-д үзүүлэв.

Зураг 4. Сэргээгдэх эрчим хүчний үр нөлөөний логик шинжилгээний жишээ



Эх сурвалж: Төслийн зөвлөхүүд

Дээрх жишээнд үзүүлсэнчлэн усан цахилгаан станц барих төслийн гарц, үр дагавар болон үр нөлөөний шалгуур үзүүлэлтийг хэмжих нэгжийн хамт "Боломжит шалгуур үзүүлэлтийн жагсаалт" -аас сонгон, бүрэн уялдуулж болохоор байна.

Харин зарим сонгогдсон зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөө болон түүнийг хэмжих шалгуур үзүүлэлт нь ТХЗНБ-ын боломжит шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтад тусгагдаагүй байна. Хэрэв тусгагдаагүй бол «Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль» болон холбогдох хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан үр дүн, үр нөлөөний үзүүлэлт, ТХЗ-ын 231 шалгуур үзүүлэлт, ОУХЗЗХ-ын шалгуур үзүүлэлтээс тухайн зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг бүрэн илэрхийлж чадах шалгуур үзүүлэлтийг сонгоно.

ТХЗНБ-ын баримт бичигт тусгагдсан "Тогтвортой хот, орон сууц ба дэд бүтэц" ангиллын хотын ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн талбайг боломжит бүх байршилд нэмэгдүүлэх санаачилгын хүрээнд хэрэгжиж буй "Соёмбо" цэцэрлэгт хүрээлэн /Хөвсгөл, Мөрөн сум/ төслийн үр нөлөөний шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар уялдуулсныг Зураг 5-т тусгав.

Зураг 5. Ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн талбайг нэмэгдүүлэх төслийн үр нөлөөний логик шинжилгээний жишээ




Эх сурвалж: Төслийн зөвлөхүүд

ТХЗНБ-ын баримт бичгийн "Боломжит шалгуур үзүүлэлтийн жагсаалт"-аас "Соёмбо цэцэрлэгт хүрээлэн /Хөвсгөл, Мөрөн сум/" төслийн урт хугацааны үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож авсан бол гарц, үр дагаврын харгалзах шалгуур үзүүлэлтүүд байхгүй байна. Төслийн гарц болон үр дагаврын шалгуур үзүүлэлтийг 2018 оны «Хот суурин газрын ногоон байгууламжийн судалгаа»-наас сонгон авсан⁸. Цаашид хөгжлийн бодлого, төлөвлөлт, салбарын бодлогын баримт бичиг, норм, дүрэм, судалгаанд тусгагдсан шалгуур үзүүлэлтээс сонгох боломжтой.

"Эрүүл мэндийн хүртээмж" ангиллын хүрээнд "Нэгдсэн эмнэлгийн барилга, 300 ор /Архангай, Эрдэнэбулган сум/" төслийн үр нөлөөг хэмжих шалгуур үзүүлэлтийг логик шинжилгээ ашиглан Зураг 6-т үзүүлэв. Энэхүү жишээний үйл явц, гарц болон үр дагаврыг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг ТХЗНБ-ын баримт бичгийн "Боломжит шалгуур үзүүлэлтийн жагсаалт"-аас сонгосон бол үр нөлөөг хэмжих шалгуур үзүүлэлтийг ОУХЗЗХ-аас гаргасан "Нийгмийн бондын үр нөлөөг тайлагнах баримт бичиг"⁹-ээс сонгосон.

Зураг 6. Эрүүл мэндийн хүртээмжийг сайжруулах үр нөлөөний логик шинжилгээний жишээ



Эх сурвалж: Төслийн зөвлөхүүд

Харин доор үзүүлсэн боловсролын жишээнд дурдсан цэцэрлэгийн ногоон барилгын төслийн гарц, үр дагавар болон үр нөлөөний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийн хамт "Боломжит шалгуур үзүүлэлтийн жагсаалт"-аас сонгон, бүрэн уялдуулж болохоор байна.

"ТХЗ 4-Чанартай боловсролыг дэмжих" зорилго нь 2023 оны "Тогтвортой Хөгжлийн Тайлан"-д Монгол Улсын хувьд хэвийн хэрэгжилттэй байгаа тул ТХЗНБ-оор санхүүжих төсөлд

⁸ Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар. (2019). Хот, суурин газрын ногоон байгууламжийн судалгаа

⁹ ISMA. (2023). Harmonised Framework for Impact Reporting for Social Bonds

боловсролын салбар сонгогдоогүй байна. Тиймээс гарц, үр дагавар болон үр нөлөөний шалгуур үзүүлэлтийг зөвхөн жишээ авах байдлаар ногоон барилга руу чиглүүлж хийсэн ба боловсролын салбарын гарц, үр дагавар, үр нөлөөг дурдаагүй болно. Цэцэрлэгийн ногоон барилгын төслийн гарц, үр дагавар, үр нөлөө нь "ТХЗ 6-Баталгаат ундны ус ариун цэврийн байгууламжаар хангах", "ТХЗ 7-Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх"-д шууд хувь нэмэр оруулж байна. Мөн "ТХЗ 9-Инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх", "ТХЗ 11-Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих", "ТХЗ 12-Хариуцлагатай хэрэглээг дэмжих", "ТХЗ 13-Уур амьсгалын өөрчлөлт" гэсэн зорилгууд руу шууд чиглэж байгааг доорх жишээгээр үзүүллээ. (Энэхүү төслийг зөвхөн жишээ болгон харуулахын тулд зохиомлоор авсан болохыг анхаарна уу)

Зураг 7. Цэцэрлэгийн ногоон барилгын үр нөлөөний логик шинжилгээний жишээ



Эх сурвалж: Төслийн зөвлөхүүд

Үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүд нь салбарын онцлогоос хамааран харилцан адилгүй өөр өөр байна. Зарим зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөө нь богино хугацаанд буюу 1–2 жилийн хооронд гарах боломжтой байна. Богино хугацаанд үр нөлөөг хэмжих боломжтой зардал, төсөл, арга хэмжээ нь ихэвчлэн урсгал зардал болон жижиг хэмжээний хөрөнгө оруулалт байна. Харин зардал, төсөл, арга хэмжээ нь томоохон хэмжээний хөрөнгө оруулалт бол үр нөлөө нь харьцангуй удаан хугацаанд гарахаар байна. Иймд тухайн зардал, төсөл, арга хэмжээний онцлогт тохирсон үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүдийг ТХЗНБ-ын баримт бичгээс сонгох шаардлагатай юм.

ТХЗНБ-ын баримт бичигт туссан боломжит үр нөлөөний шалгуур үзүүлэлттэй зардал, төсөл, арга хэмжээтэй уялдуулахдаа дараах зүйлсийг анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- 1. Үр нөлөө нь урт хугацаанд гарах томоохон зардал, төсөл, арга хэмжээ.** Жишээлбэл, "Эрдэнэбүрэнгийн 90МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барих" төслийг ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлбэл уг төслийн байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл маш өндөр байх бөгөөд, уг төслийн үр нөлөө нь богино хугацаанд гарах боломжгүй юм. ТХЗНБ-ын баримт бичигт туссан "Хүлэмжийн хийн ялгарлын бууралт (tCO₂e)" гэсэн шалгуур үзүүлэлтийг үр нөлөөний үзүүлэлтээр сонгосон. Уг төслийн үр нөлөөний шалгуур үзүүлэлт урт хугацаанд биелэх бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ихээхэн ач холбогдолтой томоохон төсөл байна.

2. Богино хугацаанд үр нөлөө нь гарах жижиг хэмжээний зардал, төсөл, арга хэмжээ. Дээр жишээ болгон авсан "Соёмбо цэцэрлэгт хүрээлэн /Хөвсгөл, Мөрөн сум/" төсөл нь богино хугацаанд үр нөлөө гарах боломжтой жижиг төсөл юм. Үр нөлөөний үзүүлэлтээр ТХЗНБ-ын баримт бичигт туссан "Нийт талбайд эзлэх ногоон байгууламжийн хувь" гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгосон. Уг төслийн үр нөлөөний шалгуур үзүүлэлт нь богино хугацаанд гарах бөгөөд тухайн бүс нутаг буюу Хөвсгөл аймгийн Мөрөн суманд ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой төсөл байна.

3. Сонгогдсон зардал, төсөл, арга хэмжээтэй уялдах ТХЗНБ-ын баримт бичигт туссан үр нөлөөний шалгуур үзүүлэлт байхгүй тохиолдол түгээмэл байна. Жишээлбэл, ТХЗНБ-ын баримт бичигт туссан "Тогтвортой хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал" ангиллын үр нөлөөний шалгуур үзүүлэлт нь 2023 оны улсын төсөвт туссан зардал, төсөл, арга хэмжээтэй уялдахгүй байна. Өөрөөр хэлбэл, "Бэлчээрийн усан хангамж /Улсын хэмжээнд/", "Арсайн газар тариалангийн услалтын систем /Увс, Улаангом сум/" зэрэг төсөлтэй "Тогтвортой хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал" ангилалд хамаарах "5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хоцрогдлын тархалт", "Үйлдвэрлэсэн органик/тогтвортой хүнсний хэмжээ", "Хүнсний аюулгүй байдлын зөрчлийн тоо", "Тогтвортой эх үүсвэртэй хүнс/бүтээгдэхүүний хувь", "Хөдөө аж ахуйн боловсрол, ур чадварын сургалтын үйлчилгээнд хамрагдсан өрхийн тоо", "Хөдөө аж ахуйн боловсрол, ур чадварын сургалтын үйлчилгээнд хамрагдсан өрхийн тоо" гэсэн 7 үр нөлөөний шалгуур үзүүлэлт уялдахгүй байна.

Хэрэв холбогдох үр нөлөөний шалгуур үзүүлэлт нь ТХЗНБ-ын баримт бичигт тусаагүй бол Сангийн яам болон салбарын яамд тухайн сонгогдсон зардал, төсөл, арга хэмжээнд тохирох үр нөлөөний шалгуур үзүүлэлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгээс сонгох шаардлагатай юм.

4. Зардал, төсөл, арга хэмжээтэй ТХЗНБ-ын баримт бичигт туссан үр нөлөөний шалгуур үзүүлэлт нь уялдаж байгаа боловч тухайн үр нөлөөний шалгуур үзүүлэлт, түүний биелэлт Монгол Улс гаргадаггүй тохиолдол байна. Жишээлбэл, ТХЗНБ-ын «6. Бохирдлоос сэргийлэх, бууруулах» ангиллын шалгуур үзүүлэлтийн "Цэвэр агаарын ач тусыг хүртэж буй хүний тоо, хүйс, хүүхдийн тоогоор илэрхийлэх" гэсэн үр нөлөөний шалгуур үзүүлэлт нь Монгол Улсад гардаггүй байна. Хэрэв Монгол Улс тухайн үр нөлөөний шалгуур үзүүлэлтийг гаргадаггүй бол Сангийн яам болон салбарын яамд тухайн сонгогдсон зардал, төсөл, арга хэмжээнд тохирох үр нөлөөний үзүүлэлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгээс сонгох шаардлагатай юм.

Тухайн зардал, төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлт нь ТХЗНБ-ын баримт бичигт тусаагүй, Монгол Улсад гардаггүй бол дараах хүчин зүйлсийг харгалзан үзэж хамаарах үр нөлөөний шалгуур үзүүлэлтийг сонгоно.

Үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүд нь хэмжигдэхүйц, харьцуулагдахуйц, хөндлөнгөөс баталгаажуулах боломжтой, тодорхой цаг хугацаанд хэрэгжих, биелэгдэх боломжтой байх шаардлагатай.

Зардал, төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах зүйлүүдийг харгалзан үзнэ.

- Шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшнийг хэмжих нэгж нь ижил хэмжигдэхүйц, харьцуулагдахуйц байх;
- Шалгуур үзүүлэлтийг шинээр зохиож мэдээлэл цуглуулах шаардлагагүй бөгөөд тогтмол цуглуулдаг бэлэн шалгуур үзүүлэлтийг сонгох (Үндэсний статистикийн хороо, Засгийн газраас гаргадаг тайлан мэдээлэл, ОУХЗЗХ-оос гаргасан зарчмууд гэх мэт);
- Зарим тохиолдолд үр нөлөөг олон жилийн хугацаанд тодорхойлох боломжгүй байдаг тул хэрэгжилтийн үйл явц, гарцад үндэслэн хүлээгдэж буй үр нөлөөг тайлагнаж болно;
- Шалгуур үзүүлэлтүүд нь зардал, төсөл, арга хэмжээний үндсэн зорилготой уялдсан байх, тэдгээрийн үр дүнтэй нийцсэн байх;
- Шалгуур үзүүлэлтийн мэдээллийг үр дүнтэй цуглуулах боломжтой эсэхийг үнэлэх; мэдээлэл цуглуулах өртөг нь мэдээллийн үнэ цэнээс илүү өндөр үнэтэй байж болохгүй;
- Зардал, төсөл, арга хэмжээний үр дүнгээс гарах хүлээгдэж буй өөрчлөлтийг илэрхийлсэн бодитой, биелэгдэх боломжтой шалгуур үзүүлэлтийг сонгох¹⁰.

2.2 ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШНИЙГ ТОГТООХ

Зардал, төсөл, арга хэмжээ нь хэрэгжсэнээр гарах ирээдүйн үр нөлөөг хэмжих эхлэлийн цэгээр шалгуур үзүүлэлтийн суурь түвшнийг ашигладаг. **Суурь түвшин** нь зардал, төсөл, арга хэмжээ эхлэх үеийн, эсвэл эхлэхээс өмнөх үеийн шалгуур үзүүлэлтийн талаарх тоон болон чанарын мэдээлэл юм. **Зорилтот түвшин** (хүлээгдэж буй үр дагавар, үр нөлөө) нь төслийн тухайн цаг хугацаанд хүрэхээр зорьж байгаа үр нөлөөний шалгуур үзүүлэлтийн тоогоор илэрхийлэгдсэн түвшин бөгөөд тодорхой цаг хугацаанд ямар ахиц өөрчлөлтөд хүрч болохыг тогтоох юм¹¹.

Үр нөлөөг хэмжихийн тулд зардал, төсөл, арга хэмжээний үйл ажиллагаанаас бий болох хүлээгдэж буй үр нөлөөний шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшнийг тодорхойлох шаардлагатай. Зорилтот түвшин нь төсөл хэвийн хүчин чадлаараа хэрэгжиж эхэлсний дараа урьдчилсан тооцсон (ex-ante) хүлээгдэж буй үр нөлөөнд үндэслэнэ. Үр нөлөөг тооцох аргачлалыг хөндлөнгийн шинжээчээр үнэлэх боломжтой байх, тухайн салбарын стандартад нийцүүлсэн байх, ил тод байх шаардлагатай. Үр нөлөөний тайланг багцын түвшинд тайлагнаж байгаа тохиолдолд багцын хүлээгдэж буй үр нөлөөг тооцно¹².

Зардал, төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн суурь түвшин нь зорилтот түвшнийг (хүлээгдэж буй үр нөлөө) тодорхойлоход ашиглагдана. Энэхүү шалгуур үзүүлэлтүүдийн суурь түвшнийг зорилтот түвшин болон бодит гүйцэтгэлтэй харьцуулан зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг хэмжинэ.

10 ICMA. (2023). Harmonised Framework for Impact Reporting for Social Bonds

11 НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр. (2023). Үр дүнд суурилсан төсөвлөлт: гарын авлага

12 ICMA. (2023). Handbook – Harmonised Framework for Impact Reporting

Зардал, төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн суурь түвшин, урьдчилан тооцсон зорилтот түвшний талаарх өгөгдөл, мэдээллийг төсөл эхлэхээс өмнө цуглуулна. Засгийн газар тодорхой зардал, төсөл, арга хэмжээний хүлээгдэж буй үр нөлөөг хянаж баталгаажуулахдаа урьдчилан тооцсон шалгуур үзүүлэлтийн холбогдох үр нөлөөний таамаглалыг тодорхойлох шаардлагатай. Үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүдийг тооцооход хэд хэдэн таамаглал дээр суурилна. Уг таамаглалуудыг тооцож буй мэргэжилтнүүд тухайн үед мэдэгдэж байгаа өгөгдөл, мэдээлэлд үндэслэн үндэслэлтэй, найдвартай таамаглал дэвшүүлэхийг зорьдог боловч зардал, төсөл, арга хэмжээний бодит үр нөлөө (ex-post) нь анхны төсөөллөөс ялгаатай байж болно.

Бонд гаргагч нь зардал, төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэний дараа баталгаажуулалт хийж байгаа тохиолдолд холбогдох бодит үр нөлөөг тайлагнах, өмнө нь тодорхойлсон хүлээгдэж буй үр нөлөөтэй харьцуулж үзүүлэх шаардлагатай юм. Харин хүлээгдэж буй үр нөлөө болон бодит үр нөлөө хоорондоо зөрөх тохиолдол гардаг. Жишээлбэл, нийгэм, эдийн засаг, улс төр, хуулийн өөрчлөлт нь анх төлөвлөж байсан хүлээгдэж буй үр нөлөөнөөс бодит байдал дээр өөр үр нөлөө гарах нөхцөлийг бий болгож байдаг. Хэрэв зардал, төсөл, арга хэмжээ хэрэгжсэний дараа бий болох бодит үр нөлөөний талаар мэдээллийг гаргах боломжгүй бол бонд гаргагч нь хүлээгдэж буй үр нөлөөнд хэрхэн явцын хяналт-шинжилгээ хийх, тайлагнах, баталгаажуулалт хийх талаар холбогдох тодруулга, нэмэлт толилуулгыг хийж байхыг зөвлөдөг.

2.3 СӨРӨГ ҮР НӨЛӨӨ

Зардал, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ТХЗ-ын хэрэгжилтийн гажуудал (SDG washing) үүсгэхгүй байхад анхаарах шаардлагатай. ТХЗ-ын хэрэгжилтийн гажуудал гэдэг нь зардал, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр байгаль орчин, нийгэм, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж байгааг үл тоомсорлох үзэгдлийг хэлдэг¹³. Тиймээс ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээний үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх боломжит бүх эерэг болон сөрөг үр нөлөөг тодорхойлж, сөрөг үр нөлөөг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлох шаардлагатай.

Сөрөг нөлөөг бууруулах шалгуур үзүүлэлтүүд нь ихэвчлэн эрсдэлээс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой байдаг. Жишээлбэл, төмөр зам барих төсөл нь ан амьтдын амьдрах орчныг сүйтгэж болзошгүй учир биологийн олон янз байдлыг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр ажил хийх шаардлагатай бөгөөд тухайн ажлын үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг мөн тодорхойлж, хэмжих шаардлагатай.

13 Boiardi, P. (2020). "Managing and measuring the impact of sustainable investments: A two-axes mapping", OECD Development Co-operation Working Papers, No. 74, OECD Publishing, Paris,

II . ТАЙЛАГНАЛ (ХУВААРИЛАЛТЫН ТАЙЛАН, ҮР НӨЛӨӨНИЙ ТАЙЛАН) _____...

ТХЗНБ-ын баримт бичгийн дагуу Монгол Улс нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн хуваарилалтын тайлан болон үр нөлөөний тайланг хөрөнгө оруулагчдад тайлагнана. Үр нөлөөний тайланг гаргах нь ТХЗ-д хүрэхэд эерэг ач холбогдол бүхий зардал, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр бий болох үр нөлөөг тодорхойлох, хэмжих, түүний хэрэгжилт, биелэлтийг хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад ил тодоор тайлагнах үндсэн зорилготой байна. Хуваарилалт, үр нөлөөний тайланг оролцогч талууд, хөрөнгө оруулагч нарт илүү ойлгомжтой, цэгцтэй, товч, тодорхой байдлаар мэдээллийг бэлтгэх нь чухал ач холбогдолтой юм.

Үр нөлөө, хуваарилалтын нэгдсэн тайланг жил бүр Сангийн яамны цахим хуудасны Шилэн данс (<https://shilendans.gov.mn>) хэсэгт нийтлэх ба тайланд материаллаг өөрчлөлт гарсан тохиолдолд өөрчлөлтийг тухай бүрд нь оруулж тайлагнана. Үр нөлөөний тайланг ТХЗНБ-ын өрийн үлдэгдэлтэй байх хугацаанд жил бүр бэлтгэнэ.

Үр нөлөөний материаллаг байдал нь нягтлан бодох бүртгэлийн материаллаг байдлаас өөр ойлголт юм. Үр нөлөөний материаллаг байдал нь мөнгөн бус мэдээлэл дээр илүү төвлөрдөг бөгөөд олон улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн гарын авлага, удирдамж, тооцох аргачлал байдаггүй.

Олон улсын тогтвортой байдлын тайлагналын санаачилга (Global Reporting Initiative) тодорхойлсноор үр нөлөөний материаллаг байдал гэдэг нь оролцогч талын үнэлгээ, шийдвэрт нөлөөлж болохуйц мэдээллийг хэлдэг¹⁴.

Хуваарилалтын тайлан болон Үр нөлөөний тайланг тусад нь гаргах шаардлагагүй бөгөөд хамтад нь нэгдсэн тайланг жил бүр гаргаж болно.

3.1 ХУВААРИЛАЛТЫН ТАЙЛАН

Зөвшөөрөгдөх зардал, төсөл, арга хэмжээнд зориулж зарцуулсан төсвийн эх үүсвэрийн нийт дүн нь ТХЗНБ-ын цэвэр татан төвлөрүүлсэн хөрөнгийн нийт дүнтэй тэнцэх хүртэлх хугацаанд жил бүрийн хуваарилалтын тайланг хөрөнгө оруулагчид болон олон нийтэд тайлагнана. Хуваарилалтын тайланд дараах дэлгэрэнгүй мэдээллийг тусгана. Үүнд:

- ТХЗНБ-ын нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн.
- ТХЗНБ-ын баримт бичгийн 2.1-д заасан зөвшөөрөгдөх ангилал, салбарт хамаарах төсөл, арга хэмжээнд хуваарилагдсан хөрөнгийн нийлбэр дүн.
- Зөвшөөрөгдсөн ангилал, салбар тус бүрийн нийгэм, байгаль орчны төслүүд (нууцлалтай холбоотой нөхцөлийн хүрээнд).
- Хэрэгжиж буй төслүүд (дахин санхүүжүүлэх) болон шинэ төслүүдэд хуваарилагдсан хөрөнгийн хувь хэмжээ.
- Татан төвлөрүүлсэн хөрөнгийн хуваарилагдаагүй үлдэгдэл.

14 GRI. (2021). Global Reporting Standard

Бонд гаргагч буюу Засгийн газар нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг зардал, төсөл, арга хэмжээ нэг бүрд хуваарилан тайлагнах эсвэл зардал, төсөл, арга хэмжээг багцлан тайлагнах боломжтой байдаг. Тухайлбал, дараах 2 хэлбэрээр татан төвлөрүүлсэн хөрөнгийг зардал, төсөл, арга хэмжээнд хуваарилан тайлагнах боломжтой юм. Үүнд:

- Үр нөлөөний тайланд тухайн бондын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих нэг эсвэл олон тооны зардал, төсөл, арга хэмжээний жагсаалтыг тусгана.
- Үр нөлөөний тайланд тухайн бондын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээний багц (олон тооны жижиг зардал, төсөл, арга хэмжээг нэг багц болгох)-ыг тусгана. Мөн нийтэд мэдээлж болохгүй, нууцлах шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээнүүд байгаа бол тэдгээрийг тусгайлан багцалж үр нөлөөний тайланд тусгаж болно. Зардал, төсөл, арга хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагч, салбар эсвэл зардал, төсөл, арга хэмжээний ижил төстэй байдлыг харгалзан үзэж багцална.

3.2 ҮР НӨЛӨӨНИЙ ТАЙЛАН

Зөвшөөрөгдөх зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөний тайланг жилд нэгээс доошгүй удаа гаргана. Зөвшөөрөгдсөн зардал, төсөл, арга хэмжээний шинж чанар, тоон мэдээллийн хүртээмжтэй байдлыг харгалзан үр нөлөөллийг хэмжих боломжит шалгуур үзүүлэлтүүдийг тайланд оруулна. Уг үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүд нь ТХЗНБ-ын баримт бичигт тусгагдсан.

Урт хугацаанд хэрэгжих зардал, төсөл, арга хэмжээний бодит үр нөлөөг бондын хүчинтэй хугацаа дууссаны дараа хэмжих, харьцуулах боломжтой болдог тул ОУХЗЗХ-ны ногоон болон нийгмийн бондын зарчмуудад зардал, төсөл, арга хэмжээний хүлээгдэж буй үр нөлөөг тайлагнахыг зөвлөдөг. Тухайлбал, томоохон хөрөнгө оруулалт нь урт хугацаанд хэрэгждэг бөгөөд үр нөлөө нь мөн урт хугацаанд гардаг. Богино хугацаанд хэрэгжих боломжтой хөрөнгийн зардал болон урсгал зардлын үр нөлөө нь бонд хүчинтэй байх хугацаанд гарах боломжтой юм. Иймд урт хугацаанд үр нөлөө нь гарах төслүүдийг тайлагнахдаа суурь түвшнийг хүлээгдэж буй үр нөлөөтэй харьцуулах, богино хугацаанд үр нөлөө нь гарах боломжтой төслүүдийг тайлагнахдаа суурь түвшнийг гүйцэтгэлээр гарсан бодит үр нөлөөтэй харьцуулж тайлагнаж болно.

1. Бондын хүчинтэй хугацаанд хэрэгжиж дууссан тухайн зардал, төсөл, арга хэмжээнээс бий болох үр нөлөөг суурь түвшнийг бодит гүйцэтгэлтэй харьцуулан тайлагнана.
2. Бондын хүчинтэй хугацаа дууссаны дараа зардал, төсөл, арга хэмжээний хэвийн үйл ажиллагаа эхлэх, үр нөлөө гарч эхлэх тохиолдолд үр нөлөөг шалгуур үзүүлэлтийн суурь түвшин болон хүлээгдэж буй үр нөлөөтэй харьцуулан тайлагнана.

Үр нөлөөний тайланг гаргахад ашиглагдах өгөгдөл, мэдээллийг Хавсралт 1-т тусгасан загвар маягтын дагуу бэлтгэж цуглуулна. Энэхүү маягт нь ОУХЗЗХ-ноос бэлтгэн гарсан ногоон болон нийгмийн бондын «Үр нөлөөний тайлагналыг зохицуулах баримт бичиг» дээр үндэслэн боловсруулагдсан¹⁵.

Үр нөлөөний тайланд санхүүгийн болон санхүүгийн бус 2 төрлийн мэдээллийг тайлагнах шаардлагатай байдаг. Зардал, төсөл, арга хэмжээнд хуваарилсан санхүүжилттэй холбоотой мэдээллийг санхүүгийн мэдээлэл, харин зардал, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр

¹⁵ ICMA. (2023). Harmonised Framework for Impact Reporting for Social Bonds

гарах үр дүн, үр нөлөөтэй холбоотой мэдээллийг санхүүгийн бус мэдээлэл гэж ангилдаг. Үндэсний аудитын газар нь холбогдох хууль, журмын дагуу санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл буюу зардал, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр нөлөөнд аудит хийнэ. Мөн шаардлагатай гэж үзвэл хөндлөнгийн баталгаажуулалт хийлгэж болно.

ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг дараах хүснэгтэд дурдсан бүтэц, агуулгын дагуу бэлтгэнэ.

Хүснэгт 1. Татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргах бүтэц, агуулга

Тайлангийн бүрэлдэхүүн хэсэг	Тайлбар
Өмнөх үг	Сангийн сайдын хөрөнгө оруулагч болон оролцогч талуудад хандсан өмнөх үг. Агуулга: Тухайн тайлант жилийн амжилт, үр дүн болон бэрхшээлийг дурдах, тайлангийн талаар товч тойм.
Танилцуулга	Засгийн газрын ТХЗ-д хүрэхэд баримталж буй бодлого, үйл ажиллагаа. Монгол Улсын Засгийн газраас гаргасан ТХЗНБ-ын талаар товч мэдээлэл. ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа зардал, төсөл, арга хэмжээний ТХЗ-д оруулж буй хувь нэмрийн талаар мэдээлэл.
Хураангуй	ТХЗНБ-ын мэдээлэл: бондын хүчинтэй хугацаа хүү мөнгөн дүн, мөнгөний нэгж хөрөнгө оруулагч нарын мэдээлэл (улс орноор, байгууллагаар, хөрөнгө оруулагчийн төрлөөр) Зардал, төсөл арга хэмжээний мэдээлэл: Татан төвлөрүүлсэн хөрөнгийн хуваарилалтын хураангуй (салбарын ангиллаар, мөнгөн дүнгээр, эзлэх хувиар) Зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөний хураангуй мэдээлэл Төслийн байршлын товч мэдээлэл Тайлангийн хураангуй хэсэгт тоо баримтуудыг график, хүснэгт, диаграмм, инфографик ашиглан товчхон бичнэ.
ТХЗНБ-ын баримт бичгийн товч танилцуулга	ТХЗНБ-ын баримт бичгийн агуулгыг товч дурдах. Дараах үе шат бүрд хийж гүйцэтгэсэн ажлыг товч тайлбарлах. Үүнд: Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт Зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох Татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлага

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн хуваарилалтын болон үр нөлөөний тайлан	ТХЗНБ-оор санхүүжүүлж буй зардал, төсөл, арга хэмжээний талаар тойм мэдээлэл оруулах ба дараах мэдээллийг багтаасан байна. Салбарын мэдээлэл Дэд салбар Төслийн нэр Төслийн товч мэдээлэл Байршил Мөнгөн дүн (санхүүжилтийн дүн) Хэрэгжих хугацаа Хүлээгдэж буй үр дүн, үр нөлөө (эсвэл бодит үр нөлөө) Хамаарах ТХЗ Төсөл хэрэгжүүлэгч байгууллага Хавсралт 3-т зардал, төсөл, арга хэмжээний талаар тойм мэдээлэл оруулах загвар хүснэгтийг оруулав.
Хэрэгжиж буй болон дууссан онцлох зардал, төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл	Хэрэгжиж буй болон дууссан зардал, төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл, хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл, хүлээгдэж буй үр нөлөө болон үр нөлөөний биелэлтийн түвшин, төслийн зураг
Хавсралт болон ашигласан эх сурвалж, ном зүй	Нэмэлт мэдээллүүд Зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөний шалгуур үзүүлэлтийг тооцоход ашигласан салбарын стандарт, аргачлалыг товч дурдах Ашигласан ном зүй,

Олон улсын тогтвортой байдлын тайлагналын санаачилга нь чанарын өндөр түвшинд тогтвортой байдлын тайланг гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор тайлагналын багц зарчмуудыг санал болгосон. Үүнд:

1. Үнэн зөв байдал
2. Тэнцвэртэй байдал
3. Тодорхой байдал
4. Харьцуулагдахуйц байдал
5. Иж бүрэн байдал
6. Тогтвортой байдал
7. Цаг хугацаа хүрээ
8. Баталгаажуулалт

3.3 ҮР НӨЛӨӨНИЙ ТАЙЛАН ГАРГАХАД АНХААРАХ АСУУДЛУУД

ТХЗНБ-ын хуваарилалт ба үр нөлөөний тайлан нь ил тод байдал, хариуцлагын нэг хэлбэр бөгөөд хөрөнгө оруулагчдад ТХЗ-ийн хүрээнд хэрэгжих зардал, төсөл, арга хэмжээнүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг авах, тэдгээрийн үр нөлөөний талаар мэдээлэл өгөх зорилготой юм.

Зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүдийг сонгохдоо тоон мэдээллийг сонгох нь чухал юм. Гэвч тэдгээрийн өгөгдөл, мэдээлэл нь хязгаарлагдмал байдаг. Үр нөлөөг ойлгоход анхаарах гол зүйлсийг доор оруулав.

Үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүд

Зардал, төсөл, арга хэмжээний хүлээгдэж буй үр нөлөөг ТХЗНБ-ын баримт бичигт тусгасан боломжит шалгуур үзүүлэлтийн жагсаалтаас сонгох. Зардал, төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтүүд нь хүлээгдэж буй үр нөлөө болон түүний цар хүрээг тодруулах зорилготой юм.

Үр нөлөөний хамрах хүрээ

Үр нөлөөний тайланд зардал, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн өмнөх үед урьдчилан тооцсон хүлээгдэж буй үр нөлөөг үндэслэх бөгөөд шууд үр нөлөөг тайлагнана.

Тодорхой бус байдал

Зардал, төсөл, арга хэмжээний хэрэгжилтээс өмнөх таамаглалд суурилан үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүдийн зорилтот түвшнийг урьдчилан тооцож, үр нөлөөг тодорхойлдог. Таамаглал гаргаж буй мэргэжилтнүүд зардал, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн өмнөх үеийн мэдээлэл, өгөгдөлд үндэслэн найдвартай таамаглал дэвшүүлдэг боловч бодит үр нөлөө нь анхны төсөөллөөс ялгаатай гарах тохиолдол байдаг. Зан төлөвийн өөрчлөлт эсвэл суурь нөхцөлийн өөрчлөлт нь зорилтот түвшнээс (төсөөллөөс) хазайхад хүргэдэг.

Харьцуулагдах байдал

Зардал, төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтүүдийн суурь түвшин (ба суурь жилүүд), мэдээлэл боловсруулах аргууд ихээхэн ялгаатай байдаг тул төсөл, салбар эсвэл багцыг хооронд нь харьцуулахдаа ялгаатай байдлыг харгалзан үзэх хэрэгтэй. Зардал, төсөл, арга хэмжээний зардлын бүтэц нь өөр байдаг тул зардлын үр ашгийн тооцоог харьцуулалт хийхдээ анхаарах шаардлагатай.

Үр нөлөөний мэдээллийг орхигдуулах болон мэдээллийн чанар

Тайланд тусгагдсан үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарлагдмал хүрээтэй байдаг. Харин зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөө нь тайланд тусгагдсан шалгуур үзүүлэлтээс илүү өргөн хүрээтэй ойлголт юм. Тиймээс зөвхөн үр нөлөөний тайланд тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдэд төвлөрөх нь бусад чухал хөгжлийн үр нөлөөг орхигдуулдаг. Тоон мэдээлэл байхгүй тохиолдолд бусад үр нөлөөг харуулахын тулд чанарын үзүүлэлтүүдийг оруулах шаардлагатай. Үр нөлөөний тайлагналын зорилго нь хөрөнгө оруулагчдад ТХЗНБ-оор

санхүүжүүлсэн зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөний талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгөх, үр дүнг ойлгоход туслах юм. Үр нөлөөний хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож, аль болох тоон үзүүлэлтээр илэрхийлэх боловч өгөгдөл, мэдээллийн хязгаарлагдмал байдлыг анхаарах нь чухал юм.

Хамтран санхүүжүүлсэн зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөө

Хамтран санхүүжих зардал, төсөл, арга хэмжээний зөвхөн ТХЗНБ-оор санхүүжих дүнг хуваарилалтын тайланд оруулах ба зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг бүхэлд нь үр нөлөөний тайланд тусгана.

Мэдээллийн эх сурвалж

Үр нөлөөний тайланд тусгагдсан зардал, төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг Монгол Улсын Засгийн газрын дотоод мэдээлэл болон олон нийтэд нээлттэй эх сурвалжаас цуглуулан тайлагнана.

IV. ӨГӨГДӨЛ, МЭДЭЭЛЛИЙН УДИРДЛАГА

Үр нөлөөг тодорхойлох, түүнийг хэмжих, тайлагнахад өгөгдөл, мэдээллийг цуглуулах, боловсруулах зайлшгүй шаардлагатай байдаг. Үр нөлөөний тайлан нь үр нөлөөний өгөгдөл, мэдээлэл дээр суурилан бэлтгэгдэнэ. Энэхүү үр нөлөөний өгөгдөл, мэдээллийг салбарын яам нь дотоод хяналт-шинжилгээ хийх, цаашлаад хараат бус байгууллагаар баталгаажуулах шаардлагатай байдаг.

Үр нөлөөний тайланг гаргах зорилготой ажлын хэсгийг зардал, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх салбарын яам бүрд байгуулах нь өгөгдөл, мэдээллийг цуглуулах, боловсруулах ажлыг хөнгөвчлөх чухал ач холбогдолтой юм. Ажлын хэсэг байгуулсны дараа тус ажлын хэсгийн ажиллах удирдамж, ажлын цар хүрээ, ажлыг хийж гүйцэтгэх хугацааг тодорхойлно. Ажлын удирдамжийн дагуу ажлын хэсэг нь үр нөлөөний өгөгдөл, мэдээллийг цуглуулснаар салбарын яам тус өгөгдөл, мэдээллийг баталгаажуулна. Баталгаажуулсан өгөгдөл, мэдээлэлд үндэслэн салбарын яам зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөний суурь болон зорилтод түвшнийг тодорхойлно. Салбарын яам бүрээс тодорхойлсон зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөний суурь болон зорилтод түвшнийг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яам хянасны дараа Сангийн яам холбогдох мэдээллийг нэгтгэнэ.


Үүний дараа Засгийн газрын баталгаажуулсан зардал, төсөл, арга хэмжээнд зориулан ТХЗНБ-ыг гаргаж, татан төвлөрүүлсэн хөрөнгийн хуваарилалтыг Сангийн яам хийнэ. Тухайн зардал, төсөл, арга хэмжээг салбарын яам хэрэгжүүлэх бөгөөд санхүүгийн гүйцэтгэлийн мэдээлэл болон үр нөлөөний биелэлтийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэнэ. Сангийн яам нь зардал, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр нөлөөний биелэлтэд явцын хяналт-шинжилгээ хийнэ.

Жил бүр үр нөлөөний тайланг гаргахад шаардлагатай өгөгдөл, мэдээллийг салбарын яам нь Сангийн яаманд хүргүүлнэ. Сангийн яам салбарын яамдаас ирүүлсэн зардал, төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр нөлөөний биелэлтэд үндэслэн үр нөлөөний тайланг гаргана. Уг тайланд хөндлөнгийн хяналт-шинжилгээ хийх шаардлагатай. Хөндлөнгийн хяналт-шинжилгээ нь санхүүгийн болон санхүүгийн бус (үр нөлөөний биелэлт) гүйцэтгэлийг баталгаажуулна. Мөн хөндлөнгийн хяналт-шинжилгээ нь үр нөлөөний тайланд дэлгэрэнгүй орсон онцлох зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөний биелэлтэд хараат бус баталгаажуулалтыг хийх шаардлагатай.

Сангийн яам нь зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөний тайланг хөрөнгө оруулагч, оролцогч талуудад нээлттэй мэдээлнэ. Үр нөлөөний тайланг хөрөнгө оруулагч болон оролцогч талуудад ойлгомжтой байдлаар хүргэхийн тулд холбогдох мэдээллүүдийг график дүрслэл ашиглан, харьцуулагдахуйц байдлаар бэлтгэх нь чухал юм.

Зардал, төсөл арга хэмжээний өгөгдөл мэдээллийг бэлтгэх, сонгох, хянах, баталгаажуулах үйл явцыг хураангуйлан Зураг 8-д үзүүлэв.

Зураг 8. Зардал, төсөл, арга хэмжээний өгөгдөл мэдээллийг бэлтгэх, сонгох, хянах, баталгаажуулах үйл явцын хураангуй



Эх сурвалж: Төслийн зөвлөхүүд

Оролцогч талууд

Үр нөлөөний тайланг боловсруулах зорилгоор мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа нь олон оролцогч талуудаас хамаардаг. Оролцогч талуудын үүргийг дараах байдлаар тодорхойлов.

Салбарын яамд нь төслийн хэрэгжүүлэгч, хариуцагчийн хувьд зардал, төсөл, арга хэмжээ, мөн түүнтэй холбоотой үр нөлөө, шалгуур үзүүлэлтийн мэдээллийг цуглуулж, шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшний мэдээллээр оролцогч талуудыг хангах, тэдгээрийг баталгаажуулах үүрэгтэй.

Сангийн яам

- I. **Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар болон Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар** нь ТХЗ-той төсвийн зарлагыг холбох ажлыг хариуцна.
- II. **Төрийн сангийн газар** нь улсын төсвийн гүйцэтгэлийн тайланг хариуцсан газрын хувьд сонгогдсон зардал, төсөл, арга хэмжээний татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлага, түүний хуваарилалт, зарцуулалтын дэлгэрэнгүй мэдээллийг хариуцна.
- III. **Санхүүгийн бодлогын газар** нь бонд гаргах үүрэг бүхий нэгж юм. ТХЗ-ын хүрээнд Санхүүгийн бодлогын газар нь ТХЗНБ-ын тайланг бэлтгэх, хөрөнгө оруулагчид хүргүүлэх гол зохицуулагч байх юм. Мөн төсөл сонгон шалгаруулах, мэдээлэл цуглуулах, жил бүр үр нөлөөг тайлагнах, хөндлөнгийн хяналт-шинжилгээ хийх байгууллагыг томилох, шаардлагатай мэдээллээр хангах үйл явцыг удирдан ажиллах үүрэгтэй.

Эдийн засаг, хөгжлийн яам нь сонгогдсон зардал, төсөл, арга хэмжээнүүдийн хөгжлийн бодлоготой уялдаж байгааг хянах, үндэсний тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдаж байгаа эсэхийг үнэлж, төслийн үр нөлөөний тайланд баталгаажуулалт хийх үүрэгтэй.

"ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээг тодорхойлох, үнэлэх, сонгох" гарын авлагын дагуу сонгогдож Засгийн газраар баталгаажсан зардал, төсөл, арга хэмжээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийг хуваарилах, үр нөлөөг тодорхойлох, түүнийг тайлагнах үйл ажиллагааг энэхүү гарын авлагад дэлгэрэнгүй оруулсан болно. Энэхүү гарын авлагыг ОУХЗЗХ-оос гаргасан зарчим, шаардлагад нийцүүлэн боловсруулав.

Зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг хэмжих, тайлагнах нь ил тод байдал, хариуцлагатай байдлыг хангахад чухал ач холбогдолтой байдаг. Харин үр нөлөө, түүнийг хэмжих талаар нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, зарчим, тодорхойлолт дутмаг байна. Учир нь салбар болон зардал, төсөл, арга хэмжээ тус бүр өөрийн гэсэн онцлогтой байдаг тул тухайн салбар, зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөө харилцан адилгүй юм. ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгийг удирдах, тус хөрөнгийг зардал, төсөл, арга хэмжээнд хуваарилах, тайлагнахдаа ТХЗНБ-ын баримт бичигт туссан зарчим, шаардлагуудыг баримтална.

Зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг урьдчилан тодорхойлох шаардлагатай бөгөөд логик шинжилгээ (Logic model) болон өөрчлөлтийн онол (Theory of change) гэсэн хоёр загварыг ашиглан үр нөлөөг тодорхойлно. ТХЗНБ-оор санхүүжих зардал, төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг ТХЗНБ-ын баримт бичигт тусгагдсан "Боломжит шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалт"-нд багтсан 91 шалгуур үзүүлэлтээс сонгоно.

Зарим сонгогдсон зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөө болон түүнийг хэмжих шалгуур үзүүлэлт нь ТХЗНБ-ын «Боломжит шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалт»-д тусгагдаагүй байна. Иймд «Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль» болон бусад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан үр нөлөөний шалгуур үзүүлэлт, ТХЗ-ын 231 шалгуур үзүүлэлт, ОУХЗЗХ-ын шалгуур үзүүлэлтээс тухайн зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг бүрэн илэрхийлж чадах шалгуур үзүүлэлтийг сонгоно.

Зардал, төсөл, арга хэмжээтэй ТХЗНБ-ын баримт бичигт туссан үр нөлөөний шалгуур үзүүлэлт нь уялдаж байгаа боловч тухайн үр нөлөөний үзүүлэлт, түүний биелэлтийг Монгол Улс гаргадаггүй тохиолдол байна. Цаашид зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөг олон талаас бүрэн тодорхойлж, хэмжихийн тулд олон төрлийн шалгуур үзүүлэлтийн мэдээллийг цуглуулж, ил тод тайлагнах шаардлагатай байна.

ТХЗНБ-оор санхүүжсэн зардал, төсөл, арга хэмжээг удирдан зохион байгуулж буй тухайн салбарын яам нь хэрэгжүүлж буй арга хэмжээний зорилго, зорилттой уялдуулан үнэн зөв, иж бүрэн мэдээллийг бусад оролцогч талуудад тайлагнах шаардлагатай. Энэ нь гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт болон үр нөлөөний биелэлтийг хянахад чухал үүрэгтэй.

Зардал, төсөл, арга хэмжээний үйл ажиллагаанаас бий болох хүлээгдэж буй үр нөлөөний шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшин (хүлээгдэж буй үр нөлөө)-г урьдчилан тодорхойлон харьцуулж үр нөлөөг хэмжинэ. Үр нөлөөний шалгуур үзүүлэлтийг хүлээгдэж буй үр нөлөөнд эсвэл үр нөлөөний бодит гүйцэтгэлд үндэслэн тайлагнах боломжтой юм.

Хавсралт 1. Зардал, төсөл, арга хэмжээний мэдээлэл цуглуулах хүснэгт

Тодорхойлолт	Төсвийн ерөнхийлөн захирагч	Тайлбар	Төслийн хэрэгжих хугацаа	Төслийн ашиглалтын хугацаа	Төсөв	ТХЗНБ-ын шаардлага хангасан хувь	Салбарын ангиллын бүрэлдэхүүн	Хуваарилагдсан дүн	ТХЗНБ-ын нийт санхүүжилт дахь эзлэх хувь	Хувь нэмэр оруулж буй ТХЗ
Төслийн нэр	үгээр	үгээр	огноо	жилээр	тегрөгөөр/ТХЗНБ-ын валютаар	хувиар	хувиар	тегрөгөөр/ТХЗНБ-ын валютаар	хувиар	Жагсаалт
Төслийн нэр	Төслийг хариуцах байгууллага	Төслийн үйл ажиллагааг 200 угт багтаан хураангуйлах	Төсөл хэрэгжиж эхлэх болон дуусах хугацаа	Төсөл ашиглалтын хугацаа	Төслийн нийт төсөв	Төслийн зарим бүрэлдэхүүн хэсэг ТХЗНБ-ын шаардлагыг хангасан бол тухайн шаардлага хангасан хувийг бичнэ	Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд өөр өөр салбарт харьяалагдаж байх үед тухайн салбарт хамаарагдах төсвийн хувь	Төсөлд хуваарилагдсан дүн	ТХЗНБ-ын нийт санхүүжилтээс төсөлд хуваарилагдсан санхүүжилтийн хувь	Төслийн хувь нэмэр оруулж буй ТХЗ-ын дугаар

Нийт дүн 100%

Дүгнэлт	Шалгуур үзүүлэлтийн суурь түвшин -1	Шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшин - 1	Шалгуур үзүүлэлт - 2	Шалгуур үзүүлэлтийн суурь түвшин - 2	Шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшин - 2	Шалгуур үзүүлэлт - 3	Шалгуур үзүүлэлтийн суурь түвшин - 3	Шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшин - 3	Мэдээлэл цуглуулалтын тэмдэглэл	Төслийн зураг
Үр нөлөөний боломжит шалгуур үзүүлэлтийн нэр	тоо	тоо	Үр нөлөөний боломжит шалгуур үзүүлэлтүүд	тоо	тоо	Үр нөлөөний боломжит шалгуур үзүүлэлтүүд	тоо	тоо	үгээр	зураг
Зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөний шалгуур үзүүлэлт	Суурь түвшнийг тодорхойлох	Зорилтот түвшнийг (хүлээгдэж буй үр нөлөө) тодорхойлох; энэ нь үр нөлөөг тооцох харуулах хэсэг юм	Зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөний шалгуур үзүүлэлт	Суурь түвшнийг тодорхойлох	Зорилтот түвшнийг (хүлээгдэж буй үр нөлөө) тодорхойлох; энэ нь үр нөлөөг тооцох харуулах хэсэг юм	Зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөний шалгуур үзүүлэлт	Суурь түвшнийг тодорхойлох	Зорилтот түвшнийг (хүлээгдэж буй үр нөлөө) тодорхойлох; энэ нь үр нөлөөг тооцож харуулах хэсэг юм	Төсөл хэрэгжүүлэгчээс оруулах нэмэлт тэмдэглэл	Төсөлтий холбоотой зураг

Хавсралт 2. Үр нөлөө болон хуваарилалтын тайлагналлын хүснэгт

Төслийн үр нөлөө														
Салбар	Төслийн нэр	Төслийн товч мэдээлэл	Байршил	Санхүүжилтийн хэмжээ (тегргеер)	Санхүүжилтийн хэмжээ (доллаароор)	ТХЗНБ-ын нийт санхүүжилт дахь эзлэх хувь	Төслийн хэрэгжих хугацаа	Төслийн ашиглалтын хугацаа	Шалгуур үзүүлэлтийн нэр	Зорилтот түвшин (хүлээгдэж буй үр нөлөө)	Бодит үр нөлөө*	Чанарын мэдээлэл	ТХЗ	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага
Үгээр	Үгээр	Үгээр	Үгээр	Мөнгөн дүн (тегргеер)	Мөнгөн дүн (ам. Доллаароор)	хувиар	огноо	жилээр	Үгээр	тоон үзүүлэлт	тоон үзүүлэлт	чанарын үзүүлэлт	Хамаарах ТХЗ-ын дугаар	үгээр
Зөвшөөрөгдсөн салбар (Сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлт, эрүүл мэндийн хүртээмж гэх мэт)	Төслийн нэр	Төслийн үйл ажиллагааг 200 үгт багтаан хураангуйлах	Төсөл хэрэгжиж буй байршил	Төсөлд хуваарилагдсан дүн	Төсөлд хуваарилагдсан дүн	ТХЗНБ-ын нийт санхүүжилтээс төсөлд хуваарилагдсан санхүүжилтийн хувь	Төсөл хэрэгжиж эхлэх болон дуусах хугацаа	Төсөл ашиглалтын хугацаа	Жишээ нь, Хүлэмжийн хийн ялгарлын бууралт	Бондын хүчинтэй хугацаанд үр нөлөө нь гараагүй бол зорилтот түвшнийг суурь түвшинтэй харьцуулж зөрүүг бичнэ.	Бондын хүчинтэй хугацаанд үр нөлөө нь гарсан бол бодит үр нөлөөг суурь түвшинтэй харьцуулна.	Чанарын үзүүлэлт бичнэ	ТХЗ-ын дугаар	Төслийг хариуцах байгууллага

Эх сурвалж: Ministry of Finance. (2023). "Green Sukuk Allocation and Impact report", Republic of Indonesia

Хавсралт 3. Үр нөлөөний тайлагналын зарчим, арга зүй

Үр нөлөөний тайланг холбогдох зарчим, арга зүйг харгалзан бэлтгэнэ. Тухайлбал, ОУХЗЗХ-оос ногоон болон нийгмийн бондын үр нөлөөний тайлан бэлтгэхэд ашиглагдах тайлагналын үндсэн зарчим, зөвлөмжийг «Үр нөлөөний тайлагналыг зохицуулах баримт бичиг»-т тусгасан. Энэхүү баримт бичиг нь ногоон болон нийгмийн ангилалд хамаарах зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөний тайлагналын шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийн холбогдох стандарт, тодорхойлолтыг бонд гаргагч нарт санал болгодог. Үр нөлөөний тайлан гаргахдаа ОУХЗЗХ-оос гаргасан "Үр нөлөөний тайлагналыг зохицуулах баримт бичиг"-т туссан харгалзан үзэх шаардлагатай зарчим, зөвлөмжийг доор дурдав.

1. Татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлэх зардал, төсөл, арга хэмжээний хуваарилалт, үр нөлөөний тайланг жилд нэгээс доошгүй удаа гаргаж байх шаардлагатай байна.

Үр нөлөөний шалгуур үзүүлэлт нь тоон болон чанарын үзүүлэлт байдаг боловч үр нөлөөг хэмжих, харьцуулахад хялбар байлгахын тулд тоон шалгуур үзүүлэлтийг тайланд ашиглахыг зөвлөдөг.

2. Үр нөлөөний тайланд зардал, төсөл, арга хэмжээг оруулж тайлагнах, эсвэл тайлангаас хасах тохиолдол байдаг. Тухайлбал, ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн зардал, төсөл, арга хэмжээ сонгогдсон эсвэл тухайн зардал, төсөл, арга хэмжээнд зориулан санхүүжилт олгогдсон бол уг зардал, төсөл, арга хэмжээг заавал үр нөлөөний тайланд оруулж тайлагнана. Харин зардал, төсөл, арга хэмжээ сонгогдсон боловч санхүүжилт олгогдоогүй болон хугацаа хожимдож олгогдсоноос үүдэн сөрөг үр нөлөө гарах (эвсэл сөрөг үр нөлөө үзүүлээд эхэлсэн) бол үр нөлөөний тайлангаас тухайн зардал, төсөл, арга хэмжээг хасна. Мөн хэд хэдэн ТХЗНБ-ын үр нөлөөний тайланг нэгтгэсэн байдлаар тайлагнаж болох бөгөөд бондын төлбөр төлөгдөж дууссан тохиолдолд тухайн бондоор санхүүжсэн зардал, төсөл, арга хэмжээг уг нэгтгэсэн үр нөлөөний тайлангаас хасна.
3. Тухайн зардал, төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээллийг товч байдлаар үр нөлөөний тайланд оруулах шаардлагатай байдаг. Тухайлбал, тухайн зардал, төсөл, арга хэмжээний нийт гэрээний мөнгөн дүн, түүнийг хэрэгжүүлж эхлэх огноо, санхүүжилт олгосон огноо, товч тайлбар зэрэг мэдээллийг үр нөлөөний тайланд тусгах боломжтой юм.
4. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг урьдчилан тодорхойлсон шалгуурыг хангасан зардал, төсөл, арга хэмжээнд хуваарилна. Албан ёсны дотоод үйл ажиллагааны тогтолцоо (ТХЗНБ-ын баримт бичгийн Татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлага, түүний хуваарилалт)-нд үндэслэн хуваарилалтыг хийж, тайланд тусгана. Энэ тохиолдолд "ТХЗ-той төсвийн зарлагыг холбох", "ТХЗ-той холбогдсон зарлагыг Бондын шалгуур үзүүлэлттэй уялдуулах", "Хориглох үйл ажиллагааны жагсаалттай тулгах" "Зардал, төсөл, арга хэмжээний санал хүргүүлэх (дэлгэрэнгүй жагсаалт)", "Зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох (хураангуй жагсаалт)", "Зардал, төсөл, арга хэмжээг баталгаажуулах" гэсэн шалгууруудыг хангасан зардал, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр татан төвлөрүүлсэн хөрөнгийг хуваарилна.

5. Бонд гаргагч буюу Засгийн газар нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг зардал, төсөл, арга хэмжээ нэг бүрд хуваарилан тайлагнах эсвэл зардал, төсөл, арга хэмжээг багцлан тайлагнах боломжтой байдаг. Тухайлбал, дараах 2 хэлбэрээр татан төвлөрүүлсэн хөрөнгийг зардал, төсөл, арга хэмжээнд хуваарилан тайлагнах боломжтой юм. Үүнд:
- Үр нөлөөний тайланд тухайн бондын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих нэг эсвэл олон тооны зардал, төсөл, арга хэмжээний жагсаалтыг тусгана.
 - Үр нөлөөний тайланд тухайн бондын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээний багц (олон тооны жижиг зардал, төсөл, арга хэмжээг нэг багц болгох)-ыг тусгана. Мөн нийтэд мэдээлж болохгүй, нууцлах шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээнүүд байгаа бол тэдгээрийг тусгайлан багц болгон үр нөлөөний тайланд тусгаж болно.
6. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зардал, төсөл, арга хэмжээнд хэрхэн хуваарилж байгаагаас хамаарч үр нөлөөний тайлан бэлтгэх аргачлал өөр байдаг.

Зардал, төсөл, арга хэмжээ нэг бүрээр хуваарилалтыг хийж байгаа бол үр нөлөөний тайланд:

- Зардал, төсөл, арга хэмжээ тус бүрийг тодорхойлох, тэдгээрийн үр нөлөөг тодорхойлох (мөн нийт санхүүжилтийн хэмжээ, зардал, төсөл, арга хэмжээний нийт дүн, тухайн зардал, төсөл, арга хэмжээний нийт зардал, төсөл, арга хэмжээний дүнд эзлэх хувь хэмжээ зэргийг тайланд тусгах)
- зардал, төсөл, арга хэмжээ нэг бүрийн үр нөлөө болон тухайн зардал, төсөл, арга хэмжээний нийт зардал, төсөл, арга хэмжээний дүнд эзлэх хувь хэмжээнүүдийг нэгтгэх

Зардал, төсөл, арга хэмжээнүүдийг багц болгон хуваарилалтыг хийж байгаа бол үр нөлөөний тайланд:

Бонд гаргагч нь тухайн зардал, төсөл, арга хэмжээний багцын нэгдсэн үр нөлөөг тусгана. Зардал, төсөл, арга хэмжээний олон багцууд байгаа тохиолдолд тэдгээр багц нэг бүрийн үр нөлөө, мөнгөн дүнг нийт багцуудын үр нөлөө, мөнгөн дүнд эзлэх хувиар гаргаж тайлагнана.

7. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зардал, төсөл, арга хэмжээнд хуваарилж, хэрэгжүүлснээр ирээдүйд гарч болох хүлээгдэж буй үр нөлөө (эсвэл үр дагавар)-г тайлагнах шаардлагатай байдаг.
- Ирээдүйд гарч болох хүлээгдэж буй үр нөлөө нь зардал, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж эхлэхээс өмнө тодорхойлогдсон байх шаардлагатай байдаг.
 - Тус хүлээгдэж буй үр нөлөө нь тухайн төсөл (зардал, төсөл, арга хэмжээ)-ийг гүйцэтгэж дууссаны дараа энгийн хүчин чадлаар ажиллах үедээ жил бүр хүрч болох хүлээгдэж буй үр дүнд үндэслэгдсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл, тухайн төсөл (зардал, төсөл, арга хэмжээ) энгийн хүчин чадлаар ажиллаж эхэлснээс хойш гарах үр дүн, үр нөлөөг төсөл эхлэхээс өмнө урьдчилан тооцож бэлэн болгосон байх шаардлагатай юм. Жишээлбэл, татан төвлөрүүлсэн хөрөнгөөр усан цахилгаан

станц барих төслийг санхүүжүүлэхээр шийдсэн бол тухайн төсөл хэрэгжсэнээр бий болох үр нөлөөг урьдчилан таамаглаж тодорхойлсон байхыг шаарддаг.

- Ирээдүйд гарч болох хүлээгдэж буй үр нөлөөг тооцох аргачлалын эх сурвалжийг хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулахыг зөвлөдөг бөгөөд тухайн хүлээгдэж буй үр нөлөө нь тухайн салбарын онцлог, стандартад нийцсэн байх шаардлагатай байдаг. Ирээдүйд гарч болох хүлээгдэж буй үр нөлөөг тооцох аргачлал нь ил тод байх шаардлагатай. Хэрэгжилтийн үе шатанд байгаа, хэрэгжиж дуусаагүй тухайн зардал, төсөл, арга хэмжээний ирээдүйд гарч болох хүлээгдэж буй үр нөлөөг тайланд тусгаж болох хэдий ч тухайн хүлээгдэж буй үр нөлөө нь бүрэн биелнэ гэсэн баталгаа байхгүй юм. Иймд, үр нөлөөний тайланд тухайн зардал, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрч болох бодит үр дүн, үр нөлөө (үр нөлөөний тайлан гаргах хугацааны туршид)-г тусгахыг анхнаасаа зорилго болгоогүй байна.
- 8. Тухайн зардал, төсөл, арга хэмжээний эдийн засгийн ашиглалтын хугацаа болон тухайн ашиглагдах хугацаанд хүлээгдэж буй нийт үр дүн, үр нөлөөг тайлагнах нь чухал ач холбогдолтой байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн зардал, төсөл, арга хэмжээний ашиглагдах хугацаанд хэр хэмжээний үр нөлөө гарсан талаарх ойлголтыг оролцогч талуудад өгдөг. Гэхдээ тухайн зардал, төсөл, арга хэмжээний ашиглагдах хугацааны туршид гарах нийт үр нөлөөг тооцох нь хялбар биш бөгөөд үр нөлөөг тооцох энгийн тооцоолол (жил бүрийн хүлээгдэж буй үр нөлөөг ашиглалтын хугацаагаар үржүүлж нийт үр нөлөөний дүнг гаргах)-оос зайлсхийх шаардлагатай байдаг. Иймд олон хүчин зүйлсийг харгалзан үзсэний үндсэн дээр тухайн зардал, төсөл, арга хэмжээний ашиглалтын хугацааны туршид гарах нийт хүлээгдэж буй үр нөлөөг тооцож гаргах шаардлагатай юм.
- 9. Бонд гаргагч нь зарим зардал, төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэний дараа баталгаажуулалт хийж байгаа бол бодит үр нөлөөг тайланд тодорхой тусгаж, урьдчилан тодорхойлогдсон хүлээгдэж буй үр нөлөөтэй харьцуулж үзүүлэх шаардлагатай юм. Харин хүлээгдэж буй үр нөлөө болон бодит үр нөлөө нь хоорондоо зөрөх тохиолдол гардаг. Жишээлбэл, нийгэм, эдийн засаг, улс төр, хуулийн өөрчлөлт нь анх төлөвлөж байсан хүлээгдэж буй үр нөлөөнөөс бодит байдал дээр өөр үр нөлөө гарах нөхцөлийг бий болгож байдаг. Хэрэв зардал, төсөл, арга хэмжээ хэрэгжсэний дараа бий болох бодит үр нөлөөний талаар мэдээллийг гаргах боломжгүй бол бонд гаргагч нь хүлээгдэж буй үр нөлөөнд хэрхэн явцын хяналт-шинжилгээ хийх, тайлагнах, баталгаажуулалт хийх талаар холбогдох тодруулга, нэмэлт толилуулгыг хийж байхыг зөвлөдөг.
- 10. Зардал, төсөл, арга хэмжээний үр дүн, үр нөлөөг харьцуулах зорилгоор бонд гаргагч нь тухайн бонд болон салбарын онцлогийг тусгасан үндсэн шалгуур үзүүлэлтийг зардал, төсөл, арга хэмжээ бүрээр гаргаж байх шаардлагатай болдог. Тухайлбал, «Ногоон бондын зарчмууд» болон «Нийгмийн бондын зарчмууд»-д салбар бүрийн онцлогт тохирсон холбогдох шалгуур үзүүлэлтийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг тусгасан байдаг. ТХЗНБ-ын хувьд үр нөлөөг хэмжих шалгуур үзүүлэлтийг мөн салбар бүрээр гаргаж ТХЗНБ-ын баримт бичигт тусгасан.
- 11. Үр нөлөөний шалгуур үзүүлэлтийг хэмжих, тооцоход зориулсан нийтээр хүлээн

зөвшөөрөгдсөн нэгдсэн стандарт байдаггүй. Бонд гаргагч нь өөрийн онцлогт тохирсон арга зүйг ашиглан хөрөнгө оруулагч нарт тайлагнана. Жишээлбэл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах гэсэн үр нөлөөний шалгуур үзүүлэлтийг тооцоолох олон арга зүй байдаг. Харин бонд гаргагч нь хүлэмжийн хийн талаар ямар төрлийн арга зүйг ашигласнаа хөрөнгө оруулагч, оролцогч талуудад танилцуулах шаардлагатай байна.

12. Хөрөнгө оруулагч нарын хувьд зардал, төсөл, арга хэмжээнүүд, салбарууд, багцуудыг хооронд харьцуулах нь хэцүү, ярвигтай байдгийг ойлгох шаардлагатай юм. Учир нь тухайн хүлээгдэж буй үр нөлөөг таамаглахад ашиглагдсан мэдээлэл, тэдгээрийг тооцох аргачлал нь хоорондоо ихээхэн зөрүүтэй байдаг. Мөн улс орон бүрд өртгийн бүтэц нь өөр байдаг тул зардал-үр дүнгийн тооцоолол (зардал-үр дүнгийн тооцоолол гэдэг нь нэгж зардал, төсөл, арга хэмжээнд оруулсан хөрөнгө оруулалтын өртөг буурах)-ийг жижиг улс оронд ашиглах нь сул тал болдог. Бонд гаргагч нь ил тод байдлыг хангах, олон төрлийн дүрэм, журам болон төсөл хэрэгжих тухайн улс, орон нутгийн суурь нөхцөл байдлыг таниулах, мэдээлэх зорилгоор зардал, төсөл, арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл (төслийн агуулга, газарзүйн байршил, зорилтот түвшин, хүн ам)-ийг үр нөлөөний тайланд тусгах боломжтой юм.
13. Бонд гаргагч нь тухайн зардал, төсөл, арга хэмжээний үр нөлөөний шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг өөр үр нөлөөний шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгж рүү хөрвүүлэх боломжтой байдаг. Тухайлбал, тохирох хөрвүүлэлтийн аргачлалыг ашиглан тонноор хэмжигдэх нүүрсийг МВт/цагт хөрвүүлэх боломжтой юм. Гэхдээ зарим төвөгтэй тооцооллууд нь зардал, төсөл, арга хэмжээний холбогдох баримт бичигт тусгагдахгүй байх эрсдэлтэй байдаг. Иймд хөрвүүлэхэд төвөгтэй тооцоолол, аргачлалаас аль болох зайлсхийхийг зөвлөдөг.
14. Ил тод байдлыг хангах зорилгоор тухайн зардал, төсөл, арга хэмжээний зарим хэсэг нь бондын шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа бол үр нөлөөний тайланд зөвхөн тус хамаарах хэсгийг тайлагнаж байхыг зөвлөдөг. Гэхдээ бонд гаргагч нь тухайн зардал, төсөл, арга хэмжээний зарим хэсгийг тайлагнах эсвэл тайлагнахгүй гэдгээ өөрөө шийдвэрлэх бүрэн эрхтэй байдаг. Татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээний зөвхөн ТХЗ (ногоон болон нийгмийн гэх мэт зардал, төсөл, арга хэмжээ)-той нийцэж байгаа, санхүүжүүлсэн хувь хэмжээгээр тухайн зардал, төсөл, арга хэмжээг тайлагнах боломжтой байна. Жишээлбэл, тухайн зардал, төсөл, арга хэмжээний 60 хувь нь ТХЗ-той нийцэж санхүүжүүлсэн, үлдсэн 40 хувь нь ТХЗ-той нийцэхгүй байгаа тохиолдолд зөвхөн 60 хувь буюу санхүүжүүлсэн зардлын хэмжээг үр нөлөөний тайланд тусгана.
15. Зардал, төсөл, арга хэмжээний хүлээгдэж буй үр нөлөөний биелэлтийн талаар тайлагнахаас гадна тухайн үр нөлөө нь биелэхгүй байх эрсдэлийг харгалзан үзэж, төслийг хэрэгжүүлэхэд учирч болзошгүй сөрөг үр нөлөөг тайлагнаж байх шаардлагатай байдаг.
16. Зардал, төсөл, арга хэмжээ нь дотроо хэд хэдэн бүрэлдэхүүн хэсэгтэй байвал бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн үр нөлөө, хамаарах санхүүжилтийн хувь хэмжээг тус

тусад нь тайлагнах боломжтой юм (Жишээлбэл, эрчим хүчний хэмнэлт, сэргээгдэх эрчим хүч гэсэн 2 бүрэлдэхүүн хэсэгтэй нэг төсөл). Мөн бүрэлдэхүүн хэсэг бүрд хэрхэн үр нөлөө болон санхүүжилтийг хуваарилсан аргачлалаа тайланд дурдах шаардлагатай байдаг. Хэрэв тус тусад нь үр нөлөө болон санхүүжилтийг тайлагнах боломжгүй бол үр нөлөөний шалгуур үзүүлэлтээ нэгтгэж тайлагнах боломжтой юм.

17. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зардал, төсөл, арга хэмжээнд хуваарилах, тайлагнахдаа бонд гаргагч нь бондтой холбоотой мөнгөн урсгалыг нэг мөнгөн тэмдэгтээр хэрхэн илэрхийлснээ тайланд дурдах шаардлагатай юм.
18. Бонд гаргагч нь үр нөлөөний тайлан гаргахад ашиглах жишиг хүснэгтүүдийг ашиглан өгөгдөл, мэдээллийг цуглуулах боломжтой юм.
19. Нийгмийн бондын зарчимд татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх зардал, төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлого, зорилт, ТХЗ-той уялдуулахыг зөвлөдөг.
20. Нийгмийн бондын зарчмын дагуу бонд гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх зардал, төсөл, арга хэмжээнээс үр шим хүртэгч зорилтот бүлэгт хамаарах хүн ам (target population)-ыг тодорхойлох шаардлагатай байдаг. Бонд гаргагч нь яагаад тухайн хүн ам нь зорилтот бүлэгт хамаарах талаар нэмэлт тайлбарыг оруулна. Тухайлбал, тусламж хэрэгцээ зайлшгүй шаардлагатай, орлого багатай, эмзэг бүлгийн иргэдийг тухайн зорилтот бүлэгт хамаарах хүн ам гэж тодорхойлох боломжтой юм.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

Alex, N. (2021). Impact Measurement and Management in Sustainable Finance. ADB. [online] Available at: <https://www.adb.org/sites/default/files/institutional-document/691951/ado2021bp-measurement-mgt-sustainable-finance.pdf>.

Boiardi, P. (2020). "Managing and measuring the impact of sustainable investments: A two-axes mapping", OECD Development Co-operation Working Papers, No. 74, OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/2ff2b2f4-en>.

Boiardi, P. and E. Stout (2021). "Towards harmonised management and measurement of impact: The experience of development finance institutions", OECD Development Perspectives, No. 15, OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/6c9891e9-en>.

Ministry of Finance. (2023). "Green Sukuk Allocation and Impact report", Republic of Indonesia. Available at: <https://ukifc.com/2024/01/23/ministry-of-finance-indonesia-green-sukuk-allocation-and-impact-report-2023-market-report-the-knowledge-portal/>

GRI. (2021). Global Reporting Standard. Available at: <https://www.globalreporting.org>.

ICMA. (2023). Handbook – Harmonised Framework for Impact Reporting. Available at: <https://www.icmagroup.org/assets/documents/Sustainable-finance/2023-updates/Handbook-Harmonised-framework-for-impact-reporting-June-2023-220623.pdf>

ICMA. (2023). Harmonised Framework for Impact Reporting for Social Bonds. Available at: <https://www.icmagroup.org/assets/documents/Sustainable-finance/2023-updates/Harmonised-framework-for-impact-reporting-for-social-bonds-June-2023-220623.pdf>.

UNDP. (2021). About the SDG Impact Standards. [online] Available at: <https://sdgimpact.undp.org/assets/About-the-SDG-Impact-Standards.pdf>

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар. (2019). Хот, суурин газрын ногоон байгууламжийн судалгаа. [online] Available at: <https://www.gazar.gov.mn/storage/reports/September2019/op0PxKu5fXKyhymqL4eO.pdf>.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр. (2023). Үр дүнд суурилсан төсөвлөлт: гарын авлага. <https://www.undp.org/mn/mongolia/publications/ur-dund-suurilsan-tosovlolt-garyn-avlaga>.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр. (2023). Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Зорилгуудтай Нийцсэн Бондын баримт бичиг.

